



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

2022

IPO ТАНИЛЦУУЛГА

IPO

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй. Мэдээлэл хүлээн авагч нь Үнэт цаас гаргагчийн тухай, үнэт цаасны тухай болон бусад холбогдох асуудлаар өөрийн хөндлөнгийн судалгаа шинжилгээг хийсэн эсвэл хийхээр зорьж байгаа гэж тооцох ба Мэдээлэл хүлээн авагч нь өөрийн мэргэжлийн санхүүгийн, хуулийн болон бусад зохих мэргэжлийн зөвлөхүүдтэйгээ зөвлөлдөнө үү гэж хүсэж байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг дамжуулах, эсхүл үнэт цаасыг санал болгох, худалдах, мөн бусад энэ төрлийн үйл ажиллагаа нь аливаа тохиолдолд Үнэт цаас гаргагчийн мэдээлэл нь энд заасан өдрөөс хойшхи цаг хугацаанд үнэн зөв хэвээр буюу үнэт цаастай холбоотой толилуулсан бусад холбогдох мэдээлэл нь тухайн баримт бичигт дурдсан өдрөөс хойшхи хугацаанд үнэн зөв гэдэг утгыг аливаа тохиолдолд агуулахгүй болно.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭСЭН НЬ АЛИВАА ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ БАТАЛГАА БИШ БОЛОХЫГ АНХААРНА УУ. ЭРХЭМ ТА ҮНЭТ ЦААС ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ ГЭДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ТУХАЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ЗАХ ЗЭЭЛД ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛЖ ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Энэхүү үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай мэдээллийг агуулахыг зорьсон болно. Танилцуулгад хөрөнгө оруулагч танд шаардлагатай мэдээллийг бүрэн оруулаагүй байж болох ба лавлах тодруулах зүйлийг Үнэт цаас гаргагч болон Андеррайтерт хандаж тодруулна уу.

БҮС НУТАГТ ӨРСӨЛДӨХҮЙЦ ХӨРӨНГИЙН БИРЖ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ НЬ:

- ✓ Эдийн засгийн, санхүүгийн салбарын тулгуур дэд бүтцийн байгууллага
- ✓ Цахим шилжилтийн идэвхтэй дэмжигч байгууллага
- ✓ Монгол улсын хамгийн олон бүртгэлтэй компанитай бирж
- ✓ Монгол улсын хамгийн олон гишүүн байгууллагатай өөрийгөө зохицуулах байгууллага
- ✓ Олон улсын стандартад нийцсэн мэдээлэл, технологийн цогц дэд бүтэцтэй

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| 2018 | 2021 |
|--|--|
| ОРЛОГО: 1.7 ТЭРБУМ | ОРЛОГО: 5.5 ТЭРБУМ |
| ЦЭВЭР АШИГ: -1.3 ТЭРБУМ | ЦЭВЭР АШИГ: 3.2 ТЭРБУМ |
| ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ: 2.5 ИХ НАЯД | ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ: 5.9 ИХ НАЯД |

АНХДАГЧ БА ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН

Хувьцаа


Компанийн бонд

ХОС¹ нэгж эрх

ХБҮЦ²

ЗГҮЦ³

2018 ба 2021 он, тэрбум төгрөг



¹ХОС – Хөрөнгө оруулалтын сан ²ХБҮЦ – Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас ³ЗГҮЦ - Засгийн газрын үнэт цаас

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ТҮҮХЭН ТОВЧОО



1991

Монголын Хөрөнгийн Бирж байгуулагдав.

1995

Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулав.

2005

Анхны IPO-г амжилттай зохион байгуулав.

2011

Лондонгийн Хөрөнгийн Бирж Групптэй “Ажлын мастер гэрээ”-г байгуулав.

2012

Олон улсад нэр хүндтэй “Миллениум Ай Ти” цогц системийг зах зээлд нэвтрүүлэв.

2018

Анхны гадаадын үнэт цаасыг давхар бүртгэв.

2015

Монголын Хөрөнгийн Бирж нь Өөрийгөө зохицуулах байгууллага статустай болов.

2013

Цахим арилжаа явагдах боломжийг бий болгов.

2020

Үнэт цаасны төлбөр тооцооны T+2 горимыг амжилттай нэвтрүүлэв.

Анхны сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжааг зохион байгуулав.

2021

FTSE Russell-ийн Хөгжиж буй зах зээлийн Ажиглалтын жагсаалтанд багтав.

2022

Хөрөнгийн биржийн шимтгэлүүдийг 10-100 хувиар бууруулсан. Системийн томоохон банкуудын IPO. Төрийн өмчийн хувьчлал: МХБ ESG стандарт. Хамгийн том ХБҮЦ: 50 тэрбум төг. Хамгийн их захиалга авсан IPO-ийн арилжааг зохион байгуулав.



АЛСЫН ХАРАА

Ил тод, нээлттэй зах зээлийн тогтолцоог бэхжүүлж, санхүүгийн төрөлжсөн хэрэгслүүд бүхий хөрвөх чадвар сайтай, бүс нутагт өрсөлдөхүйц Хөрөнгийн Бирж болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зах зээл дэх хөрөнгийн хуримтлалыг хямд өртөгтэйгөөр зуучлан хүргэж, үнэт цаасны сонгодог зах зээлийг бий болгон төлөвшүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжил дэвшилд бодит хувь нэмэр оруулна.



СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

- Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд бодит хувь нэмэр оруулна;
- Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг олон улсад таниулна;
- Дижитал шилжилтэд түүчээлнэ.

2027 онд
ЗАХ ЗЭЭЛИЙН
ҮНЭЛГЭЭ/ДНБ
25%

2027 онд
АРИЛЖААНЫ ҮНИЙН
ДҮН/ ЗАХ ЗЭЭЛИЙН
ҮНЭЛГЭЭ
10%

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ШАГНАЛУУД

2012

**The Best
Innovation**

Bloomberg TV
Mongolia Awards

2014

**Авлигаас ангид,
Сайн засаглалын
Сайн санаачилга**

Монгол Улсын
Авлигатай
Тэмцэх Газар

2018

**Арилжааны
шилдэг систем**

Waters Rankings
Awards

2020

**Шилдэг
Байгууллага**

Төрийн Өмчийн
Бодлого
Зохицуулалтын
Газар

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

САНХҮҮГИЙН
САЛБАРТ
АЖИЛСАН
НИЙТ ДУНДАЖ
ТУРШЛАГА

20
ЖИЛ

ТУЗ-ийн дарга
С. ТУЛГА

2011 оноос Сангийн яаманд ажиллаж байна. 2021 оноос Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн даргаар томилогдсон.

2011 онд БНХАУ-ын Гадаад Харилцааны их сургуулийг Олон улсын хуульчийн бакалавр, 2019 онд АНУ-ын Корнелийн их сургуулийг Төрийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн.

ТУЗ-ийн гишүүн
Д. БАЯНЗУЛ

Монголбанканд ахлах эдийн засагчаас эхлэн санхүүгийн зах зээлийн захирал хүртэл дэвшин ажилласан туршлагатай. Монголбанканд Эрсдэлийн удирдлагын газрын албаны захирлын албыг хашиж байна.

ТУЗ-ийн гишүүн
Л. НАРАНЧИМЭГ

Сангийн яаманд төрийн сангийн газрын мэргэжилтнээс эхлэн төрийн сангийн ахлах мэргэжилтэн хүртэл дэвшин ажилласан туршлагатай. Сангийн яамны Төрийн сангийн газрын төлбөр тооцооны хэлтсийн даргын албыг хашиж байна.

ТУЗ-ийн гишүүн
М. САНЖААДОРЖ

“Моннис” ХХК-аас ажлын гараагаа эхлүүлж байсан. Сангийн яаманд гэрээт ажилтнаас эхлэн төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын төсвийн зарлагын хэлтсийн дарга хүртэл дэвшин ажилласан туршлагатай. Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албыг хашиж байна.

ТУЗ-ийн гишүүн
Ч. ДОНДОГМАА

Шүүхийн шийдвэрийн гүйцэтгэх ерөнхий газарт оператор-бичээч, хяналт шалгалтын байцаагч, Хууль зүйн дотоод хэргийн яаманд ахлах мэргэжилтэн, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт Засгийн газрын референт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанд ахлах референтээр тус тус ажилласан туршлагатай. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референтийн албыг хашиж байна.

ТУЗ-ийн гишүүн
Д. ЭНХБААТАР

Сүхбаатар аймгийн намын хорооны зохион байгуулагч, Лениний музейд зохион байгуулагч, “Зотол Уул Трейд” ХХК-ийн ерөнхий захирал, “Зотол Групп” ХХК-ийн ерөнхий захирлаар тус тус ажилласан туршлагатай. Санхүүгийн зохицуулах хорооны Захиргаа удирдлагын газрын даргын түр орлон гүйцэтгэгчийн албыг хашиж байна.



Х.АЛТАЙ

Гүйцэтгэх Захирал

- ✓ 2010 оноос эхлэн “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн Тэргүүн дэд захирал, 2011-2014, 2016 оноос одоог хүртэл Гүйцэтгэх захирал
- ✓ 2015-2016 онд “Би Би Энержи” компанийн Монгол дахь төлөөлөгч
- ✓ 2010-2012 онд Монгол Улсын ЗГ-ын Ерөнхий сайдын ажлын албаны Ерөнхий сайдын зөвлөх
- ✓ 2007-2010 онд Монгол Улсын ЗГ-ын Ерөнхий сайдын ажлын алба, Ерөнхий сайдын шадар туслах
- ✓ 2004-2007 онд “Бороо Гоулд” ХХК-ийн Засгийн газартай харилцах албаны мэргэжилтэн
- ✓ МУИС-ийн Хууль Зүйн Сургууль, Эрх зүйн ухааны бакалавр, СЭЗДС, Бизнесийн удирдлагын магистр



Т. ХАШ-ЭРДЭНЭ

Бизнес хөгжлийн
газрын захирал

- ✓ 2021 онд Монгол Улсын хэрэг эрхлэх газрын Ерөнхий сайдын Эдийн засгийн бодлого хариуцсан зөвлөх
- ✓ 2017-2018 онд Монгол Улсын хэрэг эрхлэх газрын Ерөнхий сайдын дэргэдэх эдийн засгийн бодлогын зөвлөл ажлын албаны дарга, Олон нийттэй харилцах бодлого хариуцсан орон тооны бус зөвлөх
- ✓ 2017-2018 онд “Монгол Медиа Корпораци” ХХК-ийн Газрын захирал



А. МӨНХБАЯСГАЛАН

Хяналт, зохицуулалтын
газрын захирал

- ✓ 2015-2017 онд Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газрын дарга
- ✓ 2011-2013 онд “Блүүмбэрг Телевиз” ХХК-ийн Гүйцэтгэх захирал
- ✓ 2006-2015 онд “Худалдаа Хөгжлийн Банк” ХХК-ийн Маркетинг судалгааны газрын захирал



Н. ДӨЛ-ЭРДЭНЭ

Захиргаа, санхүүгийн
газрын захирал

- ✓ 2014-2016 онд “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга, Дотоод аудитор
- ✓ 2011-2012 онд “Эм Си Эс Холдинг” ХХК-ийн Санхүүгийн менежер
- ✓ 2002-2011 онд “Чингис Хаан Банк” ХХК, Хөрөнгө зохицуулалт, эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал




И. ЖАВХЛАН

Үйл ажиллагааны
газрын захирал

- ✓ 2011-2020 онд “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн ахлах мэргэжилтэн



МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ



МИЛЛЕНИУМ АЙ ТИ СИСТЕМ

ISO 9001:2008

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

6.5 их наяд

Зах зээлийн
үнэлгээ

12.4%

ДНБ-д эзлэх
хувь

183

Бүртгэлтэй
компанийн тоо

2.9%

Хөрвөх чадвар

1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТЭРГҮҮН СОНГОЛТ



Хууль эрх зүйн орчныг
төгөлдөржүүлэх



Шинэ бүтээгдэхүүн
нэвтрүүлэх



Үнэт цаас гаргагчдын
тоог нэмэгдүүлэх



Мэргэжлийн туслалцаа,
зөвлөх үйлчилгээ

3. ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ БИЙ БОЛГОХ



Жишиг нээлттэй ХК



Хүний нөөц



Ашигт ажиллагааг нэмэгдүүлэх



Системийн
байнгын шинэчлэл

2. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ТЭРГҮҮН СОНГОЛТ



Хөрөнгө оруулагчдын
эрх ашгийг хамгаалах



Мэдээллийн стандарт, ил тод,
хүртээмжтэй түргэн шуурхай
хүргэх



Зах зээлийн хөрвөх
чадварыг сайжруулах



Олон нийтийн хөрөнгийн зах
зээлийн талаар мэдлэгийг
дээшлүүлэх

ДУНД ХУГАЦААНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД ГАРГАЖ, ТӨРӨЛЖҮҮЛЭХ


| № | Санхүүгийн хэрэгсэл | Үнэт цаас гаргах хугацааны төсөөлөл | Үнэт цаасны тоо | Бүртгүүлсэн үнийн дүн - Зах зээлийн үнэлгээ |
|---|---------------------|-------------------------------------|-----------------|---|
| 1 | ХБҮЦ | 2023-2027 | 15 | 75.0 тэрбум |
| 2 | Бонд | 2023-2027 | 20 | 160.0 тэрбум |
| 3 | ХОС | 2023-2027 | 13 | 1,940.0 тэрбум |
| 4 | БАС | 2024-2027 | 5 | 40.0 тэрбум |
| 5 | Уламжлалт зах зээл | 2023-2027 | - | - |

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧДЫН ТООГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Үнэт цаас гаргагчид | Үнэт цаас гаргах хугацааны төсөөлөл | Компанийн тоо | Бүртгүүлсэн үнийн дүн - Зах зээлийн үнэлгээ |
|---|-----------------------|-------------------------------------|---------------|---|
| 1 | Банк IPO | 2023 | 3 | 3.16 их наяд |
| 2 | ААН IPO | 2024-2027 | 12 | 11.68 их наяд |
| 3 | ТӨХК IPO | 2023 | 31 | 2.48 их наяд |
| 4 | Гарааны бизнесийн IPO | 2024-2027 | 12 | 0.24 их наяд |

ЖИЛ БҮРИЙН ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Тэрбум төгрөг, хувь, 2023-2027 оны төсөөлөл



ДУНД ХУГАЦААНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ


МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Тэрбум төгрөг, хувь, 2021 он, 2022-2027 оны төсөөлөл



МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТӨСӨӨЛӨЛ

Тэрбум төгрөг, 2021 он, 2022-2027 оны төсөөлөл



Эх сурвалж: Олон Улсын Валютын Сан, 2022 оны 4 дүгээр сар, Үнэт цаас гаргагчийн үнэлгээний тайлан

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

Монгол Улсын Засгийн Газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт заасан “Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Тус үйл ажиллагааг Монгол Улсын Сангийн Яамнаас дотоодод гаргах ЗГҮЦ-ны арилжааг МХБ-ээр дамжуулан хийгдэх төлөвлөгөөтэй байгаа тул Үнэт цаас гаргагчийн цаашдын орлогын төсөөлөл тусгагдаж 2023-2027 оны дунд хугацааны бизнес төлөвлөгөөний дагуу жилд дунджаар **1.73 тэрбум** төгрөгийн арилжааны шимтгэлийн орлогыг бүрдүүлэх төсөөлөлтэй байна.


НҮҮРС БОЛОН УУЛ УУРХАЙН БУСАД БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖАА

Монгол Улсын Засгийн газрын “Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 2022 оны 10-р сарын 5-ны өдрийн 362 тоот тогтоолд заасны дагуу уул уурхайн биржийн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчныг бий болгосны үндсэнд экспортод гаргах ашигт малтмалыг биржээр дамжуулан цахим нээлттэй дуудлага худалдаагаар худалдах ажлыг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан нэвтрүүлэх ажил тусгагдсан.

Энэхүү ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК зэрэг байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2022 оны 11 дугаар сарын 10-ны өдрийн тушаалаар байгуулагдсан.

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ ҮНИЙН ДҮН


Тэрбум төгрөг, хувь, 2023-2027 оны төсөөлөл



ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ТҮҮХЭН ҮЗҮҮЛЭЛТ БА ЦААШДЫН ТӨСӨӨЛӨЛ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО


Сая төгрөг, 2021-2022 оны эхний хагас жил, 2022-2027 оны төсөөлөл



2021-2027 оны орлогын бүтцийн жилийн дундаж үзүүлэлт

| 2022-2027 оны жилийн дундаж нийлмэл өсөлт | |
|---|------|
| Бусад үйл ажиллагааны орлого | +47% |
| Хураамж, үйлчилгээний орлого | -4% |
| Арилжааны шимтгэл | +37% |


ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН БҮТЭЦ Жилийн дундаж эзлэх хувь, 2021-2027 он



ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ТҮҮХЭН ҮЗҮҮЛЭЛТ БА ЦААШДЫН ТӨСӨӨЛӨЛ


АШИГТ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сая төгрөг, 2021-2022 оны эхний хагас жил, 2022-2027 оны төсөөлөл



АШИГТ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Сая төгрөг, 2021-2022 оны эхний хагас жил, 2022-2027 оны төсөөлөл



САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД 2022Q2-2027


НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ

Сая төгрөг, 2022 оны эхний хагас жил, 2022-2027 оны төсөөлөл



НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ

Сая төгрөг, 2022 оны эхний хагас жил, 2022-2027 оны төсөөлөл



ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ ХХК ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН (2022.06.30)

| Биет хөрөнгө (мянган төгрөг) | 2021/12/31 | 2022/06/30 |
|------------------------------|------------|------------|
| Барилга, бусад байгууламж | 1,901,947 | 4,924,999 |
| Тээврийн хэрэгсэл | - | 12,100 |
| Тавилга, эд хогшил | 13,995 | 118,731 |
| Компьютер, тоног төхөөрөмж | 205,830 | 529,668 |

| Биет бус хөрөнгө (мянган төгрөг) | 2021/12/31 | 2022/06/30 |
|----------------------------------|------------|------------|
| Газар эзэмших эрх | 12,025 | 10,567,761 |
| Программ хангамж | 370,757 | 7,332,984 |

ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ



ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

| | |
|--|---|
| ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ЭЗЭМШЛИЙН ХУВЬ | 34% |
| ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОХ НЭГЖ ХУВЬЦААНЫ ҮНЭ | 100 төгрөг |
| НИЙТ ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ДҮН | 11,916 сая төгрөг |
| НЭМЖ ГАРГАХ ХУВЬЦААНЫ ТОО | 119,157,603 ширхэг |
| СТРАТЕГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД САНАЛ БОЛГОХ НӨХЦӨЛ | Нэмж гаргах хувьцааны 90 хувь хүртэлх хувь буюу 107,241,842 ширхэг энгийн хувьцаа Нэг стратегийн хөрөнгө оруулагчид нийт эзэмшлийн 5 хувиас бага эзэмшил буюу хамгийн ихдээ 17,523,176 ширхэг хувьцааг санал болгох. |
| ҮНЭТ ЦААС АРИЛЖААЛАХ АРГА | Тогтоосон үнийн арга |
| НЭМЭЛТ ХЯЗГААРЛАЛТ | Улс төрд нөлөө бүхий этгээд хувьцаа худалдан авч болохгүй |



ЗАХИАЛГА АВАХ ХУГАЦАА
2022.12.26-2022.12.30

ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР



ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР



ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР



ҮНЭЛГЭЭ



АУДИТ



ХУУЛИЙН ЗӨВЛӨХ




| ҮЗҮҮЛЭЛТ | /САЯ ТӨГРӨГ/ |
|--|---------------|
| Өөрийн хөрөнгө (2022Q2) | 23,735 |
| IPO татан төвлөрүүлэх хөрөнгө | 11,916 |
| Дансны үнэ/Book-Value (2022Q2) | = 35,651 |
| Бизнесийн Үнэлгээ | 36,754 |
| Хямдруулалтын хувь (Minority discount) | 4.6% |
| Санал болгох IPO үнэлгээ | 35,046 |
| Price/Book-value (Post money) | 1.0 |

БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ


36.7

ТЭРБУМ ТӨГРӨГ

ЭЗДИЙН ӨМЧ




ОЛОН УЛСЫН БИРЖҮҮДИЙН P/V ХАРЬЦАА



* 2022 оны 2 дугаар улирлын байдлаарх P/V-г харьцуулсан


FTSE RUSSELL АНГИЛАЛ ДАХЬ БИРЖҮҮД

FTSE RUSSEL ГРУППИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН АНГИЛЛААРХ БИРЖҮҮДИЙН ДУНДАЖ P/В ХАРЬЦАА




Эх сурвалж: Дэлхийн Биржүүдийн Холбоо, Дэлхийн Банк, 2021 он

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН БИРЖҮҮДИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД



НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗАРЦУУЛАЛТ



ЗАРЦУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| | Зарцуулах үнийн дүн (сая төгрөг) | Эзлэх хувь |
|---|-------------------------------------|------------|
| Арилжааны системийн сайжруулалт | 7,952 | 64% |
| Мэдээлэл технологийн аюулгүй байдал | 1,273 | 10.7% |
| Дотоод үйл ажиллагааны цахимжуулалт | 722 | 6.1% |
| Хөрөнгийн зах зээлийн сургалт, төв бий болгох | 2,329 | 19.5% |

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.



ХАВСРАЛТ



САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



| Санхүүгийн байдлын тайлан (сая төгрөг) | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022-II |
|---|-----------------|-----------------|-----------------|-----------------|------------------|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 830.39 | 953.43 | 554.59 | 2,729.36 | 2,511.88 |
| Дансны авлага болон бусад авлага | 299.46 | 50.02 | 84.13 | 97.26 | 66.72 |
| Бараа материал | 26.34 | 24.57 | 24.95 | 26.57 | 33.05 |
| Урьдчилж төлсөн зардал тооцоо | 16.95 | 8.34 | 8.92 | 7.67 | 6.16 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 13.16 | 13.16 | 13.16 | 13.16 | 13.16 |
| Үндсэн хөрөнгө | 2,172.00 | 2,083.73 | 2,210.71 | 2,102.23 | 5,580.75 |
| Биет бус хөрөнгө | 1,192.67 | 653.01 | 561.87 | 382.34 | 17,898.75 |
| Нийт актив хөрөнгө | 4,551.96 | 3,787.26 | 3,458.33 | 5,358.59 | 26,110.46 |
| Дансны өглөг болон бусад өглөг | 1,113.07 | 1,555.04 | 2,132.47 | 926.82 | 39.92 |
| Урьдчилж орсон орлого | 1.14 | 9.76 | 11.92 | 14.25 | 192.81 |
| Хойшлогдсон татварын өр | - | - | - | - | 2,142.37 |
| Нийт өр төлбөр | 1,214.62 | 1,604.97 | 2,205.37 | 941.07 | 2,429.17 |
| Хувьцаат капитал | 23,130.59 | 23,130.59 | 23,130.59 | 23,130.59 | 23,130.59 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 12.36 | 12.36 | 12.36 | 12.36 | 18,883.20 |
| Эздийн өмчийн бусад хэсэг | 446.32 | 446.32 | 446.32 | 446.32 | 446.32 |
| Хуримтлагдсан ашиг | (20,251.94) | (21,406.99) | (22,336.32) | (19,171.76) | (18,724.76) |
| Нийт өөрийн хөрөнгө | 3,337.34 | 2,182.29 | 1,252.96 | 4,417.52 | 23,735.36 |
| Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгө | 4,551.96 | 3,787.26 | 3,458.33 | 5,358.59 | 26,110.46 |

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ ХХК ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН (2022.06.30)

| Биет хөрөнгө (мянган төгрөг) | 2021/12/31 | 2022/06/30 |
|---------------------------------|------------|------------|
| Барилга, бусад байгууламж | 1,901,947 | 4,924,999 |
| Тээврийн хэрэгсэл | - | 12,100 |
| Тавилга, эд хогшил | 13,995 | 118,731 |
| Компьютер, тоног төхөөрөмж | 205,830 | 529,668 |

| Биет бус хөрөнгө (мянган төгрөг) | 2021/12/31 | 2022/06/30 |
|-------------------------------------|------------|------------|
| Газар эзэмших эрх | 12,025 | 10,567,761 |
| Программ хангамж | 370,757 | 7,332,984 |